

National  
Datacenter




ХАЛДЛАГАД ХАРИУ ҮЙЛДЭЛ ҮЗҮҮЛЭХ БАГ

## Хувийн шифрлэлтийн хэрэглээ нэмэгдэж байна

2018 онд “RSA conference” бага хурал зохион байгуулагдсан ба оролцсон 512 аюулгүй байдлын мэргэжилтнүүдээс судалгаа авахад “64%” нь сүүлийн үеийн геополитикийн өөрчлөлтийн улмаас хувийн шифрлэлтийн хэрэглээ нэмэгдэж байна гэж хэлжээ.


### In response to recent geo-political changes, have you increased your personal use of encryption?



Дээрх зураг нь өнгөрсөн жилээс хойших хувийн шифрлэлтийн хэрэглээний өсөлтийг харуулж байна. 2017 оны “RSA conference” бага хуралд оролцогчдоос хувийн шифрлэлтийн талаар адил асуултыг асуухад “45 %” нь адил хариулт өгсөн байна.

“Бид цахим ертөнц рүү хурдтайгаар шилжиж байна. Энэ нь бид нууцлал, аюулгүй байдалд илүү их анхаарал хандуулах шаардлагатай болж байгааг харуулж байгаа бөгөөд хувийн шифрлэлтийг ашиглан өгөгдлийг хадгалах, ч дамжуулах нь чухал ач холбогдолтой байх болно” гэж цахим аюулгүй байдлын “Venafi” компанийн дэд ерөнхийлөгч Kevin Восек мэдэгдсэн байна. “Venafi”-ийн судалгаагаар аюулгүй байдлын мэргэжилтнүүд шифрлэлтийн аюулгүй байдалд мөн анхаарал хандуулах ёстой гэж үзжээ. 2017 оны “RSA conference” бага хуралд оролцогчдын “73 %” нь шифрлэлтийн аюулгүй байдалд анхаарал хандуулах хэрэгтэй гэж үзэж байсан бол 2018 онд “84 %” болж өссөн байна.

### Are you more concerned about encryption back doors today than you were last year?



2018 оны “RSA” бага хуралд “Venafi” компанийн дэд ерөнхийлөгч Kevin Восек хэлэхдээ “судалгаанаас харахад мэргэжилтнүүд хувийн шифрлэлтийн аюулгүй байдалд анхаарал хандуулах нь нэмэгдэж байна. Цахим гэмт хэрэгтнүүд цахим ертөнцийн бүхий л сул талыг ашиглаж хохирол учруулсаар байгаа нь биднийг илүү хүчирхэг байхыг сануулсаар байна.” гэжээ.